



ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ТАВИЛГА” ХК-ИЙН 2019 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ
ӨДРӨӨР ДУУСВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

Огноо: 2020 оны 02 дугаар сарын 10 өдөр

80803183-

Өлзийт Экаунт Аудит ХХК

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, Бумцэндийн гудамж, 65-1 тоот

E-mail: auditulziit@gmail.com

Утас: 70130460, 99109702, 88117655

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН
“ТАВИЛГА” ХК-ИЙН ЗАХИРАЛ
Д.ЦАГААНЦООЖ ТАНАА**

Санхүүгийн тайлангийн Аудитын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Бид 2019 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд, тодруулгаас бүрдсэн “Тавилга” ХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар “Тавилга” ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд, Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль дүрэм журмын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Зөрчилгүй дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартуудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн дагуу үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудиттай холбоотойгоор бидний хүлээх үүрэг хариуцлага нь дээр тодорхойлсон бусад мэдээллийг унших бөгөөд ингэхдээ санхүүгийн тайлан болон аудитын явцад олж авсан мэдлэгтэй материаллаг зөрүүтэй эсвэл ямар нэг байдлаар материаллаг буруу илэрхийлэгдсэн эсэхийг анхаарч үзэх юм. Аудитын явцад бидний олж авсан мэдээллийн хүрээнд залруулагдаагүй материаллаг буруу илэрхийлэл ажиглагдаагүй.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн үнэлэмжээр, сонгон авсан горимуудад алдаа болон залилангийн улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээг багтаан санхүүгийн тайланд аудитын ажлыг гүйцэтгэхэд аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц асуудлууд нь аудитын гол асуудлууд болдог. Эдгээр асуудлуудыг аудитын явцад санхүүгийн тайланг бүхэлд нь хамруулан авч үзсэн бөгөөд аудитын агуулгын хүрээнд дүгнэлт гаргахад нөлөөлсөн ба асуудлуудын улмаас дүгнэлтээ хязгаарлаагүй.

Компанийн үүрэг хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Удирдлага компанийн санхүүгийн тайланг гаргах болон үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах чадамжтай байх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Аудитын явцад тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой материаллаг тодорхой бус байдал бидэнд ажиглагдаагүй

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлан гэсэн ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцдог.

Энэхүү тайлан нь Монгол улсын “Компанийн тухай” хуулийн 94 дүгээр зүйлд зааснаар хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу хийгдэж аливаа өөр зорилго агуулаагүй.

“Өлзийт экаунт аудит” ХХК-ийн аудитын баг тайланг бэлтгэлээ.

“Өлзийт экаунт аудит” ХХК-ийн

Захирал



Ц.Бямбажав

Огноо: 2020 оны 02 дугаар сарын 10 өдөр

"ТАВИЛГА" ХК
АУДИТЛАГДСАН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН
2019 оны 12 сарын 31 өдөр

	Тод	2018.12.31	(төгрөгөөр) 2019.12.31
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4	161,879,111.25	133,503,771.85
Дансны авлага			
Татвар,НДШ-ийн авлага	6	11,604,134.30	6,880,116.98
Бусад авлага			
Бусад санхүүгийн хөрөнгө			
Бараа материал	9	650,191.00	
Урьдчилж төлсөн зардал/тооцоо			
Бусад эргэлтийн хөрөнгө			
Эргэлтийн хөрөнгийн дүн		174,133,436.55	140,383,888.83
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	11	316,774,314.96	307,299,015.94
Биет бус хөрөнгө	12	156,217,257.00	156,217,257.00
Биологийн хөрөнгө			
Урт хугацаат хөрөнгө оруулалт			
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө			
Хойшлогдсон татварын хөрөнгө			
Урт хугацаат хөрөнгө оруулалт			
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө			
Бусад эргэлтийн бус хөрөнгө			
		472,991,571.96	463,516,272.94
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		647,125,008.51	603,900,161.77
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг			
Цалингийн өглөг			
Татварын өр	17	7,286,797.17	13,084,816.12
НДШ-ийн өглөг	17	6,184.01	
Богино хугацаат зээл			
Хүүний өглөг			
Ногдол ашгийн өглөг			
Урьдчилж орсон орлого			
Ноогдол ашгийн өглөг			
Урьдчилж орсон орлого			
Бусад богино хугацаат өр төлбөр			
Богино хугацаат өр төлбөр		7,292,981.18	13,084,816.12
Урт хугацаат зээл			
Урт хугацаат өр төлбөрийн дүн		7,292,981.18	13,084,816.12
Өр төлбөрийн нийт дүн		7,292,981.18	13,084,816.12
Эзэмшигчдийн өмч			
Хувийн өмч	21	459,872,521.89	459,872,521.89
Хувьцаат	21	12,275,400.00	12,275,400.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл			
Эздийн өмчийн бусад хэсэг			
Хуримтлагдсан ашиг	22	167,684,105.44	118,667,423.76
Эзэмшигчдийн өмчийн дүн		639,832,027.33	590,815,345.65
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		647,125,008.51	603,900,161.77


Аудитор

 Ч.Эрдэнэжав

"ТАВИЛГА" ХК
АУДИТЛАГДСАН ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
2019 оны 12 сарын 31 өдөр


Үзүүлэлт	Тод	2018.12.31	(төгрөгөөр) 2019.12.31
Борлуулалтын орлого /Цэвэр/	23	231,818,181.82	92,754,190.93
Борлуулалтын өртөг			
Нийт ашиг (алдагдал)		231,818,181.82	92,754,190.93
Түрээсийн орлого		-	
Хүүний орлого	25		6,430.62
Ногдол ашгийн орлого			
Эрхийн шимтгэлийн орлого			
Бусад орлого			
Борлуулалт, маркетингийн зардал	28	17,471,033.75	
Ерөнхий ба удирдлагын зардал	28	241,746,384.75	140,365,572.24
Санхүүгийн зардал			
Бусад зардал	30	1,198,900.00	
Гадаад валютын ханшын зөрүүний олз (гарз)			
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)			
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)			
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)			
Бусад ашиг (алдагдал)			
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-	28,598,136.68	47,604,950.69
Орлогын татварын зардал			
Татварын дараах ашиг (алдагдал)	-	28,598,136.68	47,604,950.69
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)			
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	28,598,136.68	47,604,950.69
Бусад дэлгэрэнгүй орлого			
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү			
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			
Бусад олз (гарз)			
Орлогын нийт дүн	-	28,598,136.68	47,604,950.69
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)			

Аудитор


 Ч.Эрдэнэжав

"ТАВИЛГА" ХК
АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
 2019 оны 12 сарын 31 өдөр

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан Ашиг	(төгрөгөөр)
				Өмчийн дүн
2017 оны 12 -р сарын 31- ээрх үлдэгдэл	472,147,921.89		167,684,105.44	639,832,027.33
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга Залруулсан үлдэгдэл Бусад дэлгэрэнгүй орлого				-
Өмчид гарсан өөрчлөлт Зарласан ногдол ашиг Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
2018 оны 12-р сарын 31- ээрх үлдэгдэл	472,147,921.89	-	167,684,105.44	639,832,027.33
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга Залруулсан үлдэгдэл Тайлант үеийн цэвэр ашиг Бусад дэлгэрэнгүй орлого			(1,411,730.99)	(1,411,730.99)
Залруулсан үлдэгдэл Тайлант үеийн цэвэр ашиг Бусад дэлгэрэнгүй орлого	472,147,921.89	-	166,272,374.45	638,420,296.34
Тайлант үеийн цэвэр ашиг Бусад дэлгэрэнгүй орлого			(47,604,950.69)	(47,604,950.69)
Өмчид гарсан өөрчлөлт Зарласан ногдол ашиг Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
2019 оны 12-р сарын 31- ээрх үлдэгдэл	472,147,921.89	-	118,667,423.76	590,815,345.65

Аудитор  Ч.Эрдэнэжав

"ТАВИЛГА" ХК
АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
 2019 оны 12 сарын 31 өдөр

(төгрөгөөр)
 2019.12.31

	Тод	2018.12.31	
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
<u>Мөнгөний орлогын дүн</u>		257,070,200.00	102,262,001.03
Бараа борлуулсаны, үйлчилгээ үзүүлсний орлого			98,121,961.03
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого			
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө			
Буцаан авсан албан татвар			
Татаас, санхүүжилтийн орлого			
Бусад мөнгөн орлого		257,070,200.00	4,140,040.00
<u>Мөнгөн зарлагын дүн</u>		244,832,114.69	120,493,771.05
Ажиллагчдад төлсөн мөнгө		50,540,661.28	62,988,629.13
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө		14,051,789.77	18,190,279.23
Бараа материал худалдан авахад төлсөн		180,237,663.64	1,727,050.00
Ашиглалтын зардалд төлсөн			21,223,430.90
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө			1,612,500.00
Хүүний төлбөрт төлсөн			
Татварын байгууллагад төлсөн			
Даатгалын төлбөрт төлсөн			
Бусад мөнгөн зарлага		2,000.00	14,751,881.79
<u>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</u>		12,238,085.31	(18,231,770.02)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
<u>Мөнгөн орлогын дүн</u>		-	6,430.62
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого			
Биет бус хөрөнгө борлуулсны орлого			
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого			
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого			
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт			6,430.62
Хүлээн авсан хүүний орлого			
Хүлээн авсан ногдол ашиг			
<u>Мөнгөн зарлагын дүн</u>		3,234,600.00	10,150,000.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		3,234,600.00	10,000,000.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн			
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн			
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн			
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа			150,000.00
<u>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн</u>		(3,234,600.00)	(10,143,569.38)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Мөнгөн орлогын дүн			
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан			
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан			
Төрөл бүрийн хандив			
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг			
Мөнгөний зарлагын дүн			
Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө			
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн			
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн			
Төлсөн ногдол ашиг			
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал			
<u>Санхүүгийн мөнгөн гүйлгээний дүн</u>		-	-
Валютын ханшийн зөрүү			
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		9,003,485.31	(28,375,339.40)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		152,875,625.94	161,879,111.25
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		161,879,111.25	133,503,771.85

Аудитор  Ч.Эрдэнэжав